



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#6

2022 он

IX сар

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

Тогтвортой Хөгжлийн Боловсролын www.esd.mn веб сайт ажиллаж эхэллээ



НҮБ-аас 2015 онд “ТХБ-ын Дэлхий нийтийн үйлийн хөтөлбөр (2015-2019)”-ийг баталж, хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн ололт амжилт, сургамжид суурилж дараагийн 10 жилд дэлхий нийтээр хэрэгжүүлэх “ТХБ-2030” нэртэй үйлийн шинэ хүрээ, замын зураглалыг боловсруулж, 2019 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 74 дүгээр хуралдаанаар баталсан.

“ТХБ-2030”-д ядуурлыг бууруулах, хүн амын эрүүл, аюулгүй байдлыг хангах, боловсролын чанар хүртээмжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг чиглэлээр 17 зорилго, 169 зорилтыг томьёолж, эдгээрийг 2030 он хүртэл хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байна. Эдгээр зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд ТХБ чухал үүрэг гүйцэтгэхийг анхааруулж, улс орон бүрд НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын баталсан “ТХБ-ын дэлхий нийтийн үйл ажиллагааны хөтөлбөр (2015-2030)”-т нийцүүлэн үндэсний бодлого, хөтөлбөрөө боловсруулан хэрэгжүүлэхийг зөвлөмжилсөн байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 209 дүгээр тогтоолоор баталсан “Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр”-т бүх нийтэд ТХБ-ыг эзэмшүүлэх, улмаар Монгол улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилго агуулсан байдаг.

Монгол Улсын Засгийн газар, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр “Тогтвортой хөгжлийн боловсрол” энэхүү төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

ТХҮБ-2030-аар тогтвортой хөгжлийн гурван тулгуур: нийгэм-соёл, эдийн засаг, байгаль орчинд үндэслэсэн Монгол Улсын хөгжлийн гол зарчим, алсны харааг тогтоосон.

ТХБ-оор дамжуулан Монгол Улсын иргэдэд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хариуцлагатай, тэгш хүртээмжтэй, тогтвортой ирээдүйг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилготой төслийн II үе шатанд Төслийн түшиц байгууллага болох Боловсролын Судалгааны Үндэсний хүрээлэн (БСҮХ) дээр байгаль орчин, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн харьяа агентлаг, төслийн орон нутаг дахь хэрэгжилтийг хариуцаж ажиллах ТББ-ын төлөөллөөс бүрдсэн Техникийн Зөвлөн Зохицуулах Үндэсний баг ажиллаж байна.

ТХБ-II төслийн хүрээнд www.esd.mn веб сайтыг ITools компанитай хамтран хийж 6 дугаар сард ашиглалтад оруулсан бөгөөд сайтыг ажиллуулах журмыг шинээр батлан гаргалаа. Энэхүү журмаар www.esd.mn веб сайтад тогтвортой хөгжлийн боловсролтой холбоо бүхий мэдээ мэдээллийг оруулах, түгээх, ашиглах, үйл ажиллагаанд хяналт тавих, шинэчлэх, веб сайтын аюулгүй байдлыг хангахтай холбогдох харилцааг зохицуулахаар тусгасан.

www.esd.mn веб сайт нь Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих, хөгжүүлэхтэй холбоотой бүхий л мэдээ, мэдээлэл, сургалтын материал, контентыг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэх үндэсний хэмжээний цахим хэрэгсэл болж буйгаараа онцлогтой юм.



Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ тодорхойлох, сургалтын хөтөлбөрийг боловсруулж байна

Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн чадамжийн бүтцийн хүрээ, иргэдийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах зорилгоор Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/310 дугаар тушаалаар “Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлох, сургалтын хөтөлбөр боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг БШУЯ, ЦХХХЯ, БСҮХ, БЕГ, БМТТ, И-Монгол академи, МУБИС, МУИС, ШУТИС, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүүхдийн сан, IRIM судалгааны хүрээлэн зэрэг 12 байгууллагын 22 гишүүнтэйгээр байгуулагдан ажиллаж байна.

Ажлын хэсгийг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал М.Итгэл (Ph.D) ахалж байгаа бөгөөд ажлын хэсэг Монгол Улсын Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлж, суурь судалгаа авч, 3 түвшний сургалтын хөтөлбөр боловсруулах юм.



БСҮХ -ийн хэвлэмэл танилцуулгын англи хувилбарыг гаргав

БСҮХ -ийн хэвлэмэл танилцуулгын англи хувилбарыг Adobe Photoshop программ дээр бэлтгэн, хэвлүүлсэн. Танилцуулга нь А4 хэмжээтэй 4 нүүр бүхий, БСҮХ -гийн зорилго, зорилтууд, үнэт зүйлс, стратеги төлөвлөгөө, сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн голлох бүтээлүүд, зохион байгуулсан үйл ажиллагааг зэргийн мэдээллийг агуулсан байна. Англи хэл дээрх танилцуулгын эхийг монгол хэл рүү хувилж хэвлүүлэхэд бэлэн болгосон.



Их, дээд сургуулийн “Багш, бага боловсрол” жишиг сургалтын хөтөлбөр боловсруулна

СХҮСБС-ны секторын эрдэм шинжилгээний ажилтнуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг нь “бага боловсролын багшийн сургалтын төлөвлөгөө, жишиг хөтөлбөр боловсруулах”-аар дотоод болон гадаадын их, дээд сургуулийн багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийх ажлын хуудас (Ажлын хуудас №1, №2, №3)-ыг боловсруулж, зарим улс орны багш бэлтгэх сургалтын хөтөлбөртэй холбоотой баримт, материалыг орчуулсан. Улмаар ажлын хуудсаа ашиглан шинжилгээ хийж байна. Үүний зэрэгцээ багшийн мэргэжлийн чадамжийн бүтэцчилсэн хүрээ боловсруулах ажлыг хийж байна.

“Хөгжим заах арга зүй” хичээлийн хөтөлбөрт шинжилгээ хийв

Бага ангийн багш бэлтгэдэг их, дээд сургуулийн хөгжмийн хичээлийн хөтөлбөрт шинжилгээ хийхдээ баримт бичгийн болон харьцуулалтын аргыг ашигласан. Зарим үр дүнгээс дурдвал судалгаанд хамрагдсан их, дээд сургуулийн 83 хувь нь хөгжмийн хичээлийг мэргэжлийн чиглэлд заавал судлах, 8 хувь нь мэргэжлийн чиглэлд сонгон судлах, 9 хувь нь мэргэжлийн суурь чиглэлд заавал судлахаар тус тус

сургалтын төлөвлөгөөндөө тусгасан байна. Боловсролыг дахин төлөвлөх, бэхжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, их дээд сургуулиудын хоорондын түншлэлийг дэмжих, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд нэгдсэн, шинэлэг сургалтын хөтөлбөр шаардлагатай гэж судлаачид үзжээ. Судалгааны үр дүнгээр эрдэм шинжилгээний өгүүлэл бэлтгэсэн байна..

“Байгалийн ухааны цахим сургалтын хөтөлбөрийг турших ажил”-ын хүрээнд

БШУ-ны сайдын 2022 оны А/336 дугаар тушаалаар “Байгалийн ухааны цахим сургалтын хөтөлбөрийг турших үйл ажиллагааны удирдамж”-ийг баталсан бөгөөд энэ ажлын хүрээнд боловсруулсан байгалийн ухааны цахим контентыг ерөнхий боловсролын 50 сургуульд туршихаар төлөвлөсөн байна. Туршилтын ажлыг БЕГ-ын даргын 2022 оны А/224 дүгээр тушаалаар ажлын хэсэгт тус секторын 3 эрдэм шинжилгээний ажилтан мэргэжил арга

зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Бэлтгэл ажлын хүрээнд байгалийн ухааны цахим контентын агуулгатай 5 дугаар ангийн “Хүн ба байгаль” хичээлийн холбогдох агуулгыг судалж, нийт 24 сэдвийг сонгосон. Тус хичээлтэй холбогдох цахим контентын 8-ынх нь агуулга, арга зүй, зохион байгуулалт, хэрэглэгдэхүүнийг судалж, сайжруулах саналыг STEMWerkz зөвлөх багт хүргүүлсэн байна.

Хос хэлний АХИС арга зүйг туршин нэвтрүүлэх гарааны болон үр дүнгийн судалгаа



Судалгааны мэдээллийг 2021 онд асуулга болон ярилцлагын аргаар цуглуулсан бөгөөд АХИС

(Агуулга болон хэлтэй Интеграцчилан Суралцах) аргыг турших туршилтын үйл ажиллагааг зохион байгуулсан. Туршилтад нийт 270 нэгж хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, туршсан байна. Судалгааг 2 үе шаттай зохион байгуулсан бөгөөд гарааны болон үр дүнгийн тайланг нэгтгэж байна.

Судалгааны үр дүнг БШУЯ, БСҮХ, БЕГ болон

Дэлхийн банкны холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулсан.

Түүнчлэн туршилтын үр дүнд үндэслэн цаашид хос хэлээр сургалтаа явуулдаг ерөнхий боловсролын сургуульд баримтлах сургалтын бодлогын чиглэлийг гаргасан бөгөөд түүнийг БШУЯ болон орон нутгийн БШУГ-т танилцуулаад байна.

Дээд боловсролын байгууллагад хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрийн давхцлын судалгаа



Монгол улсад сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй дээд боловсролын 86 байгууллагын сүүлийн 5 жилд хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрийн давхцал болон суралцагч, төгсөгчдийн тоон судалгааг боловсролын түвшингээр гарган боловсруулалтыг хийж тайланг БШУ-ны дээд боловсролын газарт хүргүүлсэн.

Энэхүү шинжилгээний үр дүнд үндэслэн

эрдэм шинжилгээний өгүүлэл бэлтгэж “The 2nd International Symposium on Computer Science, Computer Engineering and Educational Technology 2022”- олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Current Situation and Prospects of Higher Education of Engineering and Technology in Mongolia” нэртэй илтгэл хэлэлцүүлэхээр илгээгээд байна.

Хүний нөөцийг чадавхжуулахад чиглэсэн сургалт, хэлэлцүүлэг-1

СХҮСБСС-оос “Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэл” сэдвийн доор сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал болон хөтөлбөр сурах бичиг боловсруулах хүний нөөцийг чадавхжуулах сургалтын модулийн бүтэц, дизайн боловсруулах талаар нэгдсэн ойлголттой болох, санал бодлоо солилцох сургалт, хэлэлцүүлгийг 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулав. Сургалт, хэлэлцүүлэгт СХСБҮС, БТСС-ын эрдэм шинжилгээний ажилтнууд оролцсон бөгөөд тэдэнд модулийн бүтцийг танилцуулж, түүнийг хэрхэн боловсронгуй болгох дадлага ажил зохион байгуулав. Эрдэм шинжилгээний ажилтнууд сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал боловсруулах чиглэл, төлөвлөгөөний төсөл, хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэл хийх хүний нөөцийг чадавхжуулах сургалтын модулийн бүтэц, хүний нөөцийг чадавхжуулах сургалтын дизайн, түүнийг сайжруулах талаар саналаа нэгтгэж, хэлэлцүүлэг өрнүүллээ.



Хүний нөөцийг чадавхжуулахад чиглэсэн сургалт, хэлэлцүүлэг-2



Боловсролын бодлого боловсруулах, төлөвлөх, сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал боловсруулах чиглэлээр эрдэм шинжилгээний ажилтнуудыг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлгийг ҮБХИС-ийн Батлан хамгаалах удирдлагын академитай хамтран 2022 оны 9 дүгээр сарын 23-нд зохион байгуулсан бөгөөд нийт 25 эрдэм шинжилгээний ажилтан хамрагдав. Сургалт, хэлэлцүүлэгт БХБЯ-ны

Барилгын хөгжлийн төвийн хэлтсийн дарга С.Давааням: “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” сэдвээр, БСҮХ-ийн эрдмийн зөвлөлийн гишүүн, зөвлөх профессор О.Пүрэв: “Монгол үндэсний болон монгол хүний үнэт зүйлийг тодорхойлох нь” сэдвээр танилцуулга хийж, сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал боловсруулах ажлын чиглэлийн талаар хэлэлцүүлэг хийв.

“Эрүүл мэндийн боловсрол-Сургуулийн өмнөх боловсрол” сургалт



Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийг дэмжих багшид зориулсан “Эрүүл мэндийн боловсрол” гарын авлагыг хэрэглэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор сургагч багш бэлтгэх сургалтыг 2022 оны 9 дүгээр сарын 28-наас 30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Сургалтад аймаг, нийслэлийн БШУГ-ын СӨБ хариуцсан мэргэжилтэн, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, БЕГ-ын мэргэжилтнүүд оролцсон.

Сургалтад бага насны хүүхдийн хөгжил, суралцахуй, зан үйл, сэтгэл хөдлөл, сэтгэцийн эрүүл мэнд, хүүхдийн эрх, хамгаалал, амны хөндийн эрүүл мэнд болон хоол, шим тэжээлийн чиглэлээр

мэргэшсэн судлаач эрдэмтэд, мэргэжлийн багш нар мэдээлэл танилцуулсан нь сургагч багш нарт үнэ цэнтэй байв. Сургалтын гарын авлага нь СӨНХ-ийн эрүүл мэндийн боловсролыг дэмжихэд чиглэж, сургалтын арга зүйн санааг боловсруулсан төдийгүй хэрэглэгдэхүүний хамтаар хэвлэгдэн гарснаараа онцлогтой байсан. Сургалтын явцад “Эрүүл мэндийн боловсрол” гарын авлагыг бага насны хүүхдийн эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой бүтээл болсныг тодорхойлж, багш нарт тулгарч буй асуудлын талаар хэлэлцэж, гарын авлагын арга зүйн санааг хэрхэн хэрэгжүүлэх дадлага ажлыг хамтдаа хийв.



БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр БСҮХ, БЕГ-ын холбогдох мэргэжилтэн, сургагч багш нар хамтран “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийг таниулах, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх, үлгэрчилсэн хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх зорилготой сургалтыг 21 аймгийн БШУГ, 9 дүүргийн боловсролын хэлтсийн хүүхдийн эрх, хамгаалал

хариуцсан мэргэжилтэн болон нийгмийн ажилтнуудын төлөөлөл бүхий 90 гаруй албан хаагчийг хамруулан 2022 оны 9 дүгээр сарын 19 нөөс 20-ны өдрүүдэд зохион байгуулав. Тэд эцэг эх, асран хамгаалагчийг ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд оролцоход дэмжлэг үзүүлэх, түншлэх, хичээлээс гадуурх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах нэгдсэн ойлголттой болж, хэрэгжүүлэх арга зүйд суралцлаа.

ЕБС-ийн 1 дүгээр ангид цагаан толгойн үсэг таниулах, уншуулж сургах арга зүйг турших үйл ажиллагааны бэлтгэл хангагдлаа

Боловсрол шинжлэх ухааны яамны 2022 оны 5/4158 дугаартай “Хамтран ажиллах тухай” албан бичгээр уламжилсан “Бага боловсролын I ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрийн хүрээнд цагаан толгойн үсэг таниулах, уншуулж сургах арга зүйг турших” үйл ажиллагааг нийслэлийн 8 дүүргийн 13, орон нутгийн 2, нийт 15 ерөнхий боловсролын сургуулийн 30 бүлэгт зохион байгуулах гэж байна. Туршилтад тэдгээр бүлэгт хичээл заадаг бага ангийн 30 багш, 1200 гаруй сурагч хамрагдана. Туршилтын үйл ажиллагааг БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд мэргэжил,

арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах бөгөөд зохион байгуулалтын ажлын хэсэгт БЕГ, НБГ, МУБИС-Багшийн сургуулийн төлөөллүүд багтсан байна. Туршилт энэ оны 10 дугаар сарын сүүлийн долоо хоногт эхэлнэ. Бэлтгэл ажлын хүрээнд туршилт зохион байгуулах баг бүрдүүлэх, танилцуулах хийх, нэгдсэн ойлголтод хүрэх уулзалт хийх, туршилтын удирдамж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, туршилтын сургуулиудын багш, сурагчдын мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг ажлыг хийсэн байна.

Бага боловсролын монгол хэлний унших эхэд тавих шаардлага боловсруулна

Дэлхийн банкны санхүүжилтээр БСҮХ “Бага боловсролын монгол хэлний унших эхийн сан бүрдүүлэх” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд бага боловсролын монгол хэлний унших эхэд тавих шаардлага боловсруулж, түүнд нийцсэн эхийн сан бүрдүүлэхээр ажиллаж байна. БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд эхэд тавих шаардлагатай холбоотой баримт бич-

-гийн шинжилгээ хийхээр холбогдох материалын жагсаалтыг гаргаж, 2000 оноос хойш ерөнхий боловсролын сургуульд хэрэгжиж ирсэн бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр болон олон улсын эх хэлний сургалтын хөтөлбөрийн харьцуулсан шинжилгээ хийж байна. Харьцуулсан шинжилгээнд ашиглах ажлын хуудас 1, унших эхийн сэдэв, агуулгыг

тодорхойлохтой холбоотой ажлын хуудас 2-ыг тус тус боловсруулжээ. Түүнчлэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх багтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаар төслийн ажлын эрх зүйн орчин бүрдсэн байна. Эхэд тавих шаардлага боловсруулахтай холбоотой баримт бичгийн судалгаа хийх ажлын хуудас, аргачлалыг багт танилцуулж, шинжилгээний ажлыг эхэлсэн байна.

Монгол хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн чадварын судалгааны тайланг эцэслэн боловсруулах ажил хийгдлээ



БСҮХ-ийн ХХСС-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд 9-р сард 3-5, 6-10, 11-14, 15-17 настай Монгол хүүхдийн хөгжлийн онцлогийг бие бялдарын өсөлт, хөгжил гэсэн 2 чадамжаар, танин мэдэхүйн анхаарал, хүртэхүй, ой, тогтоолт, сэтгэхүй, хэл ярианы чадваруудаар, нийгэмшлийг өөрийн хандлага, сэтгэл хөдөлгөөн-харилцаа, дасан зохицох чадвар, ээнэгшилт, үнэт зүйлийн, нийгмийн хэм хэмжээг дагах чадваруудаар үр дүнг боловсрууллаа. Ийнхүү судалгааны үр дүнд тулгуурласан монгол хүүхдийн хөгжлийн талаарх нэг сэдэвт бүтээл монографи тэрчлэн судалгааны үр дүнд тулгуурлан 3 айн бүтэцтэй шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажил хийгдэж байна.



Сургагч багш болон амжилттай суралцаж төгссөн багш нарт сертификат гардуулах үйл ажиллагаа



“Англи хэлний зуны эрчимжүүлсэн сургалт”-ын сургалтын хөтөлбөр боловсруулсан доктор С.Чимэд, заах арга зүйн хувьд үнэтэй хувь нэмэр оруулсан Aleta Loftis, үндэсний сургагч багшаар ажилласан 27 сургагч багш нарт ТАЛАРХАЛ, сургалтыг амжилттай төгссөн багш нарт 3 кредит бүхий СЕРТИФИКАТ гардуулах ёслолын арга хэмжээг энэ оны 9 дүгээр сарын 7-ны өдөр 15 цагт Багшийн хөгжлийн ордонд зохион байгууллаа.



Арга хэмжээг нээж Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга С.Санжаабадам үг хэлж, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал М.Итгэл, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир нар сургагч багш нарт талархал, суралцагч багш нарт сертификат гардууллаа.